



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/210

Хэрлэн сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Б.Цогт-Оршихоос аймгийн Засаг даргад холбогдуулан Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлд, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.1, 28.2.2, 28.2.3, 28.2.4, 28.2.5, 28.2.6, дахь хэсэгт заасан бүрэн эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Дарханбаатар, Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга Н.Чанцал нарт олгож өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсугай.

2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд аймгийн Засаг даргыг төлөөлж оролцохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн /Б.Дарханбаатар/, Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга /Н.Чанцал/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

011022